



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 1629

Бэрх хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгө зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дах заалт, Бэрх хотын онцгой комиссын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" тэмцээнд оролцох сурагчдад дэмжлэг үзүүлж 2.200.000 төгрөгийг, онцгой комиссын цэргийн бэлтгэл сургуулалтад оролцох албан хаагчдын хувцас хэрэглэлийн зардалд 1.300.000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Шаардагдах 3.500.000 (гурван сая таван зуун мянган) төгрөгийг захирагчийн эрсдэлийн сангаас холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гаргахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН